



СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Эрүүл аюулгүй орчны хэм хэмжээг тодорхойлох, стандартчилах, шинэчлэн сайжруулах ажлыг нийгэм, эдийн засгийн хөгжилд нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах нь энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үндэслэл болно.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын болон Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээр конвенцуудад тусгагдсан Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-ын I үе шатын 4 дэх заалтад “хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ” гэж, Зорилт 4.4-ийн I үе шатад “Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө” гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6.2-т “Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж... төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ” гэж, 6.3-т “Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж... тусгай зөвшөөрлийн тоог бууруулна” гэж заасан нь тохирлын үнэлгээний тогтолцоог шинэчлэх ерөнхий чиг баримжааг тодорхойлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.1.6.1-т “Стандартчилал, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн чанар хүртээмжийг сайжруулна” гэж тусгасан нь энэхүү шинэчилсэн найруулгын зорилготой шууд нийцнэ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахыг Стандарт, хэмжил зүйн газарт даалгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 181 дүгээр тогтоолын 1.3.15 дахь хэсэгт энэхүү хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахыг Стандарт, хэмжил зүйн газарт даалгасан. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.2 дахь заалтад Шадар сайдын эрхлэх асуудалд стандартчилал, хэмжил зүйн асуудал, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал, лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлт гэж тусгасан.

Энэхүү харилцааг анх удаа зохицуулах зорилгоор 1994 онд Монгол Улсын Их Хурлаас Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн бөгөөд, эдийн засаг, нийгмийн харилцааны онцлогт нийцүүлэн 2003 онд Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, 2017 онд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг тус тус батлан, мөрдүүлж иржээ.

Дээрх хууль зүйн үндэслэл, шаардлага нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үндэслэл болно.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Өнөөгийн байдлаар Монгол Улсад 6,657 стандарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа боловч стандартын хэрэгжилт хангалтгүй байгаагаас хүний эрүүл мэнд, амьдрах орчинд ноцтой сөрөг үр дагаварууд гарсаар байна. Практик шаардлагыг тодорхойлох зорилгоор дараах асуудлуудыг тусгайлан дурдаж байна.

а) Стандартын нэр томъёоны хоёрдмол байдал

Одоо мөрдөгдөж буй хуулийн 4.1.2 дахь заалтад стандартыг “сонгон хэрэглэх баримт бичиг” гэж томъёолсон нь иргэн, хуулийн этгээдэд стандарт дагаж мөрдөх үүрэггүй гэсэн буруу ойлголтыг төрүүлж байна. Дэлхийн худалдааны байгууллагын Техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн Хавсралт 1-д зааснаар стандарт нь дангаараа заавал дагаж мөрдөх үүрэг үүсгэхгүй боловч хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татагдсан тохиолдолд заавал дагаж мөрдөхөөр тусгасан байдаг. Энэ зарчмыг хуульд тодорхой томъёолох шаардлагатай.

б) Тохирлын үнэлгээний байгууллага

Засгийн газрын 2018 оны “Жагсаалт журам шинэчлэн батлах тухай” 291 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан 644 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ тохирлын үнэлгээнд заавал хамрагдах шаардлагатай. Гэвч одоо ажиллаж буй нийт 65 итгэмжлэгдсэн байгууллагын хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүчин чадал хяналт тавихад хангалтгүй байна. Хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо хязгаарлагдмал хэвээр байгаа нь зах зээлийн өрсөлдөөнд саад болж байна. Цаашид Үндэсний итгэмжлэлийн төвөөс итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагууд аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн чанарын удирдлагын тогтолцооны ISO 45001 стандартын баталгаажуулалт хийж гэрчилгээ олгож байгаа боловч, бодит байдалд эдгээр аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл буурахгүй байх, харин ч ISO стандартын хэрэгжилтийг хангасан гэх боловч Хүнсний аюулгүй

байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэхгүй байх асуудал газар авсан. Энэ нь тохирлын үнэлгээний байгууллагад итгэмжлэл олгодог Үндэсний итгэмжлэлийн байгууллагын хараат бус, ил тод, хариуцлагатай байдал, түүнд тавих хяналтын механизм сул байгааг харуулж байна.

в) Лабораторийн тогтолцоо

Монгол Улсын хэмжээнд нийт 224 лаборатори (төрийн 54, хувийн 170) үйл ажиллагаа явуулж байгаагаас 174 нь итгэмжлэгдсэн байна. Лабораторийн харилцааг 61 хуулийн 87 заалтаар тус тус зохицуулж байгаа нь харилцан мэдээлэл солилцох, шинжилгээний үр дүнг нэгтгэх боломжийг хязгаарлаж, давхардсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байна. Нэгдсэн мэдээллийн систем байхгүй улмаас салбар дундын уялдаа алдагдсан байна. Зохистой зохицуулалтгүй бол хувийн хэвшлийн лабораториуд хумигдах, бүх лаборатори төрд төвлөрөх эрсдэлтэй учраас ангилал, зохицуулалтыг шударга өрсөлдөөн, хувийн хэвшлийн оролцоог хангасан зарчмаар тогтоох шаардлагатай байна.

Лабораторийг хүчин чадал, хамрах хүрээ, хүний нөөц, үйл ажиллагааны чиглэлээс хамаарч лаборатори, хяналтын лаборатори, лавлагаа лаборатори гэж ангилал зэрэглэлийг хуульчлан тогтоох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар лаборатори байгуулах, хүний нөөцийг бэлтгэх асуудлыг төрийн бодлогоор дэмжих нь зүйтэй байна.

Салбарын хяналт, шалгалт, тохирлын үнэлгээний чиг үүрэг эрхлэгч мэргэжилтнүүдийн ажиллах орчин, хүний нөөцийн бодлого тодорхойгүй, хариуцлагын тогтолцоо сул байгаа нь стандартын хэрэгжилтийг алдагдуулж байна. Гомдол, маргаан шийдвэрлэх зохицуулалт хуульчлагдаагүйгээс иргэд, хэрэглэгчдийн эрх хамгаалагдахгүй байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1.Зорилго

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан стратеги, чиг хандлагад нийцүүлэн:

- Дэлхийн худалдааны байгууллагын Техникийн саад тотгорын тухай хэлэлцээр шаардлагад нийцсэн, олон улсын нийтлэг практикт суурилсан стандартчилалын эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

- Үндэсний итгэмжлэлийн байгууллагын хараат бус, ил тод, хариуцлагатай үйл ажиллагааг хувийн хэвшлийн идэвхтэй оролцоотойгоор хөгжүүлэх, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн итгэмжлэлийн үйл ажиллагаа явуулах тогтолцоог бий болгох;

- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дэвшилтэд технологи бүхий лаборатори байгуулах, лабораторийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгон нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих;

- Иргэн, хуулийн этгээд стандартыг олж авах, хэрэглэх, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох мэдээллийг хүргүүлэх нөхцөлийг хуулийн шинэчилсэн найруулгад тусгана.

2.2.Нэр томьёо, тодорхойлолтын шинэчилсэн зохицуулалт

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн нэр томьёоны хоёрдмол байдлыг арилгаж, олон улсын гэрээ, конвенцод нийцсэн байдлаар хуулийн төсөлд тусгана.

2.3.Стандарт батлах эрх хэмжээний зохицуулалт ба Нийслэлий иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөрчлийг шийдвэрлэх механизм

Стандарт болон техникийн зохицуулалтын зохицуулах хүрээг үндэсний болон орон нутгийн түвшинд тодорхой ялгаатай тогтоох замаар чиг үүргийн давхардал, эрх хэмжээний зөрчлийг шийдвэрлэнэ. Үүнд:

- **Үндэсний стандарт, техникийн зохицуулалт** нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалахад тавигдах нийтлэг хэм хэмжээг тогтоох, бүх нутаг дэвсгэрт нэгэн жигд хэрэгжих агуулгатай байна;

- **Улаанбаатар хотын стандарт** нь дэд бүтэц, хотын тохижилт, барилга, зам, талбайн хаягжилт, нийтийн эзэмшлийн орон зайн аюулгүй байдал зэрэг орон нутгийн онцлогт тулгуурласан асуудлыг зохицуулах, ингэхдээ үндэсний стандарт болон техникийн зохицуулалтын шаардлагыг биелүүлэхэд чиглэх агуулгатай байна;

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас стандарт батлаж заавал дагаж мөрдүүлж байгаа нь Дэлхийн худалдааны байгууллагын Техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн Хавсралт 1-д заасан "стандарт" ба "техникийн зохицуулалт"-ын ялгаатай тодорхойлолттой зөрчилдөж байгаа тул дараах механизмаар шийдвэрлэнэ;

- Хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноос хойш 12 сарын дотор Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан 68 стандартыг тус бүрд нь хянан шалгаж, (а) үндэсний стандарттай нэгтгэх, (б) техникийн зохицуулалт болгон шилжүүлэх, эсвэл (в) хүчингүй болгох шийдэлд хүрнэ.

- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуульд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дэд бүтэц, хотын тохижилт, барилга, зам, талбайн хаягжилт, нийтийн эзэмшлийн орон зайн аюулгүй байдалтай холбогдсон асуудлаар "орон нутгийн техникийн зохицуулалт" батлах эрхтэй боловч үндэсний стандарт, техникийн зохицуулалт, Дэлхийн худалдааны байгууллагын Техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн зарчмыг зөрчихгүй байх нөхцөлийг тусгайлан заана;

- Орон нутгийн засаг захиргааны байгууллага техникийн зохицуулалт батлахаас өмнө заавал Стандарт, хэмжил зүйн газарт бүртгүүлж, нийцлийн магадлан дүгнэлт авах журам тогтоосноор чиг үүргийн давхардлаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдэнэ.

2.4.Тохирлын үнэлгээний бодлого хариуцсан байгууллагын чиг үүрэг

Стандартчилалын тухай хуульд тусгагдсан тохирлын үнэлгээний бодлого хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодруулан, бусад салбарын байгууллагатай уялдаа холбоог хангана. Тухайлбал, Стандарт хэмжил зүйн газар нь бодлого, аргачлал, мэдээллийн нэгтгэл; итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагууд нь гэрчилгээжүүлэлт, баталгаажуулалт гэсэн шатлалт тогтолцоог хуульчилна.

2.5. Үндэсний итгэмжлэлийн байгууллагын хараат бус, ил тод, хариуцлагатай байдал, хяналтын механизм

Тохирлын үнэлгээний байгууллагад итгэмжлэл олгодог Үндэсний итгэмжлэлийн байгууллагын хараат бус, ил тод, хариуцлагатай байдлыг хангах, түүнд тавих хяналтын тодорхой механизмыг хуульчилна. Үндэслэл нь Үндэсний итгэмжлэлийн төвөөс итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагууд аж ахуйн нэгж, байгууллагуудад ISO 45001 стандартын баталгаажуулалт хийж гэрчилгээ олгож байгаа боловч уг гэрчилгээтэй аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл буурахгүй, харин ч ХАБЭА-н хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэхгүй байх асуудал газар авсан явдал юм. Иймд итгэмжлэлийн тогтолцоог дараах зарчмаар бэхжүүлнэ:

- **Хараат бус байдал.** Үндэсний итгэмжлэлийн байгууллага нь өөрийн итгэмжилсэн тохирлын үнэлгээний үйлчилгээтэй ашиг сонирхлын зөрчилгүй, төрийн захиргааны болон арилжааны байгууллагаас удирдлага, санхүүжилт, шийдвэр гаргалтын хувьд хараат бусаар ажиллах эрх зүйн баталгааг хуульчилна; ISO/IEC 17011 олон улсын стандартад нийцсэн засаглалын зохион байгуулалттай байна;

- **Ил тод байдал.** Итгэмжлэлийн журам, шалгуур, шийдвэр, хүчингүй болсон болон түдгэлзүүлсэн итгэмжлэлийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй цахим бүртгэлээр тогтмол нийтэлдэг байх; итгэмжлэлийн үнэлгээний тайлан, аудитын дүгнэлтийг тогтоосон хэмжээнд нийтэд хүртээмжтэй болгоно;

- **Хариуцлагатай байдал.** Итгэмжлэгдсэн байгууллагын олгосон гэрчилгээ нь техникийн зохицуулалт, ХАБЭА болон бусад салбарын хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэх үүргийг орлохгүй болохыг тодорхой тогтоон, нийцэлгүй итгэмжлэлийн үр дүнд нийтийн ашиг сонирхол хохирсон тохиолдолд итгэмжлэгдсэн байгууллага болон Үндэсний итгэмжлэлийн байгууллагын хариуцлагын шатлалыг хуулиар тогтоон, нөхөн төлбөр, итгэмжлэл түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээг авна;

- **Хяналтын механизм.** Үндэсний итгэмжлэлийн байгууллагын үйл ажиллагаанд (i) дотоод хяналтын зөвлөлийн жил тутмын аудит, (ii) олон улсын ILAC, IAF-ын хамтын үнэлгээ (peer evaluation)-ийн тогтмол хамрагдалт, (iii) хараат бус хөндлөнгийн хяналтын зөвлөлийн (мэргэжлийн холбоо, хэрэглэгчийн төлөөлөл, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллөөс бүрдсэн) хяналтыг хуульчилна; итгэмжлэгдсэн байгууллагын ажиллагаанд гомдол, маргаан гарсан тохиолдолд бие даан шийдвэрлэх журмыг тогтооно;

- **Эрсдэлд суурилсан давтан үнэлгээ.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал зэрэг нийтийн ашиг сонирхолд өндөр нөлөөтэй стандартын баталгаажуулалт хийдэг итгэмжлэгдсэн байгууллагуудыг эрсдэлд суурилсан хуваарийн дагуу тогтмол давтан үнэлгээнд хамруулна.

2.6. Лабораторийн шаталсан тогтолцоо, шударга өрсөлдөөн, хувийн хэвшлийн оролцоо

Нийт лабораторийг чиг үүрэг, чадамж, маргаан шийдвэрлэх байдлаар нь ангилан, ISO/IEC 17025:2017 олон улсын стандартад нийцсэн дараах гурван шатны бүтцийг хуульчилна:

- **Лаборатори** - орон нутаг дахь аймаг, нийслэлийн дүүрэг болон хувийн хэвшлийн лаборатори.

- **Хяналтын лаборатори** - анхан шатны лабораторийн шинжилгээ, хэмжилтийн үр дүнгийн чанар, үнэн зөв байдлыг баталгаажуулах зорилгоор давтан

шинжилгээ хийх, баталгаажуулалт болон хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий дараагийн шатны лаборатори.

- **Лавлагаа лаборатори** - ISO/IEC 17025 болон ISO 15189-д нийцсэн, хэмжил зүйн нэгдмэл байдлыг хангах, аймаг, дүүргийн лабораторийн шинжилгээний үр дүнгийн маргааныг эцэслэн шийдвэрлэх, олон улсын харьцуулалтад оролцох дээд шатны лаборатори;

Лабораторийн ангилал, зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшлийн оролцоо, шударга өрсөлдөөнийг хангах, төрийн хэт оролцооноос сэргийлэх дараах зарчмыг хуульчилна:

- **Төр-хувийн хэвшлийн түншлэл.**

Лабораторийн үйлчилгээг төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар үзүүлэх, төрийн худалдан авалтын хүрээнд хувийн лабораторийн итгэмжлэгдсэн үйлчилгээг хүлээн зөвшөөрөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

- **Зах зээлийн зарчимтай нийцсэн ангилал.**

Лабораторийн ангилал, тоо, байршлыг тогтоохдоо зах зээлийн эрэлт, өрсөлдөөний зарчимд нийцүүлж, хувийн хэвшлийн лабораторийг дэмжих,

Бүх итгэмжлэгдсэн лаборатори стандартад нийцсэн нэгдсэн мэдээллийн системд холбогдож, шинжилгээний үр дүнг бүртгэдэг болно.

2.7.Стандарт боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах, гомдол шийдвэрлэх тогтолцоо

Стандартыг боловсруулж батлах, хянан шалгах, гомдол шийдвэрлэх бие даасан тогтолцоог хуульчилна. Ил тод байдлын зарчмын дагуу батлагдах стандартын төслийг нийтэд нийтэлж, тайлбар, санал авах журмыг хуульд тусгана. Стандартыг тогтмол хянах, хүчингүй болгох хугацааны хязгаарыг тогтоон, шинэчлэлийн хариуцлагыг салбарын холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

2.8.Техникийн зохицуулалт батлах процессын үе шат, хяналт

Техникийн зохицуулалт боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцыг дараах тодорхой үе шатаар хуульчилна:

- Зохицуулалтын нөлөөллийн шинжилгээ хийх, олон нийтийн хэлэлцүүлэг явуулах;

- Эрсдэлийн ангилалд суурилан зохицуулалтыг боловсруулах — эрсдэл өндөр: заавал батлах, эрсдэл бага: зөвлөмжийн шинжтэй зохицуулалт;

- Оролцогч байгууллагуудын эрх, үүргийг тодорхой хязгаарлах, хариуцлагыг шатлан тогтоох;

- Хэрэгжилтийг тогтмол хянах, биелэлтийн тайланг нийтэд мэдээлэх.

2.9.Нэгдсэн мэдээллийн сан

Хуулийн төсөлд дараах мэдээллийн сангуудыг нэгдсэн нэг тогтолцоонд нэгтгэнэ: стандартчилал, техникийн зохицуулалтын баримт бичгийн мэдээллийн сан; итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын мэдээллийн сан; лабораторийн шинжилгээний үр дүнгийн мэдээллийн сан; техникийн хяналтын үр дүнгийн мэдээллийн сан; сорьц тогтоолгон баталгаажсан үнэт металлаар хийсэн бүтээгдэхүүний болон гэрчилгээтэй эрдэнийн чулууны мэдээллийн сан; баталгаажуулалтын шинжээчийн мэдээллийн сан; стандарт, техникийн

зохицуулалтын хэрэгжилтийн хяналтын мэдээллийн сан. Мэдээллийн сан нийтэд нээлттэй хэсэгтэй байж, иргэд, хэрэглэгчид онлайнаар хандах боломжтой болно.

2.10.Хэрэгжилтийн хяналт, хариуцлагын шатлалт тогтолцоо

Стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн зөрчилд дараах шатлалт хариуцлага хүлээлгэнэ:

- Анхааруулга, зааварчилгаа — анхны зөрчил, хэрэгжилтийг засах боломжтой тохиолдолд;

- Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлээс татан авах захирамж — хэрэглэгчийн эрх зөрчигдсэн тохиолдолд;

- Зөрчлийн тухай хуульд заасан торгуулийн арга хэмжээ — давтан эсвэл ноцтой зөрчил;

- Тусгай зөвшөөрөл, итгэмжлэлийг түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгох — нийтийн эрх ашигт шууд аюул учруулсан тохиолдолд.

Иргэд болон аж ахуйн нэгжид зах зээлийн хяналтын үр дүнгийн тайланг улирал тутам нийтлэн, нэгдсэн мэдээллийн сангийн нийтэд нээлттэй хэсэг болон мэдээллийн хэрэгслээр дамжуулан стандартын шаардлага, зөрчлийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд хүргэнэ.

2.11.Иргэд, хэрэглэгчдийн эрхийн хамгааллын зохицуулалт

Хэрэглэгчид нийлүүлэгдэж буй бараа, үйлчилгээнд тавигдах стандарт, техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан эсэхийн талаарх мэдээллийг үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс шаардах эрхтэй болохыг хуульчилна. Иргэний хяналтын механизмыг мэдээллийн сан, гомдол хүлээн авах тогтолцоогоор дэмжинэ.

2.12.Стандартыг шинэчлэх, чадавхжуулах зохицуулалт

Батлагдсан стандартыг тогтмол шинэчлэх, хүчингүй болгох зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, чадавхжуулах, үүрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгана. Олон улсын стандартыг нутагшуулах ажлын дэс дарааллыг журмаар тогтооно.

2.13.Тохирлын үнэлгээнд хяналт, шалгалт ашиглах зохицуулалт

Төрийн хяналт шалгалтад тохирлын үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрч ашиглах эрх зүйн боломжийг хуульчлах замаар давхардсан шалгалтыг бууруулна. Итгэмжлэгдсэн байгууллагын дүгнэлт нь хяналт шалгалтын үр дүнтэй тэнцэх хүчинтэй байхыг хуульд тусгана.

2.14.Лабораторийн нэгдсэн мэдээллийн сан, судалгааны дэмжлэг

Лабораторийн шинжилгээний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэн, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжинэ. Судалгааны байгууллагатай хамтран ажиллах, шинжилгээний үр дүнг хуваалцах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

2.15.Төр-хувийн хэвшлийн түншлэл - Санхүүгийн болон бүтцийн механизм

2.16. Олон улсын стандартыг нэг удаа ашиглах зохицуулалт

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх хөгжлийн бүтээн байгуулалтад шаардлагатай, үндэсний стандартаар батлагдаагүй олон улсын стандартыг Засгийн газрын зөвшөөрлөөр эх хэл дээр нь нэг удаа ашиглах боломжийг хуульчилна. Энэ

зохицуулалт нь байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлд хугацааны хязгаарлалттайгаар мөрдөгдөнө.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

3.1.Нийгмийн үр дагавар

Стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн хяналт бэхжсэнээр иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж буй чанар муутай бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо буурна. Хэрэглэгчдийн мэдлэг, оролцоо нэмэгдэж, стандартын хэрэгжилтэд иргэний хяналтын тогтолцоо бий болно. Лабораторийн шаталсан тогтолцоо нэвтэрснээр лаборатори иргэн, хуулийн этгээдэд чанартай үйлчилгээ үзүүлнэ.

3.2.Эдийн засгийн үр дагавар

Тохирлын үнэлгээний тогтолцоо олон улсын нийтлэг практикт нийцсэнээр дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг олон улсад зөвшөөрүүлэх, гадаад худалдаа, экспортыг хөнгөвчлөх нөхцөл сайжирна. Чиг үүргийн давхардал буурч, хувийн хэвшлийн тохирлын үнэлгээний болон лабораторийн байгууллага хөгжиж, шударга өрсөлдөөн идэвхжсэнээр салбарын инноваци, өрсөлдөх чадвар нэмэгдэж, шинэ ажлын байр бий болно.

3.3.Хууль зүйн үр дагавар

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон үндэсний байгууллагуудын хооронд стандарт батлах чиг үүргийн давхардал арилж, эрх зүйн зөрчил шийдвэрлэгдэнэ. Үндэсний болон Улаанбаатар хотын стандартын зохицуулах хүрээ ялгаатай, харин уялдаатай тогтоогдсоноор үндэсний нэгдсэн тогтолцоо бэхжинэ. Үндэсний итгэмжлэлийн байгууллагын хараат бус, ил тод байдлыг хуульчилснаар Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага, Олон улсын итгэмжлэлийн байгууллага (ILAC, IAF)-д хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл бүрдэнэ.

3.4.Авах арга хэмжээний санал

- Стандарт, хэмжил зүйн газар нийслэлийн ИТХ-ын 68 стандарт хянах ажлын хэсгийг хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 30 хоногийн дотор байгуулж ажиллуулах;
- Үндэсний итгэмжлэлийн байгууллагын хараат бус, ил тод байдлыг хангах журам, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2026 онд багтаан баталж, ISO/IEC 17011-д нийцсэн ILAC, IAF-ын хамтын үнэлгээнд тогтмол хамруулах;
- Лабораторийн мэдээллийн системийн нэгтгэлийн ажлыг 2027–2028 онд эхлүүлэх;
- Тохирлын үнэлгээний болон лабораторийн байгууллагын тоог нэмэгдүүлэх зорилт тавин, хувийн хэвшлийн оролцоог дэмжих хөтөлбөрийг боловсруулах.

ДӨРӨВ.ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛЬТАЙ УЯЛДАХ, ДАГАЛДАХ ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---